

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/95/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Авирмэд Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨЛГИЙ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
С.ХҮДЭРБАТ ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/95/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200200232

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,480,200.00	11,611,130.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	270,000.00	00.00
311	Кассад байгаа бэлэн мөнгө	270,000.00	270,000.00
31110	Төгрөг	270,000.00	270,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	00.00	-270,000.00
3121	Төгрөг	00.00	-270,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	-270,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,210,200.00	11,611,130.00
354	Хангамжийн материал	10,210,200.00	11,611,130.00
35410	Бичиг хэргийн материал	210,700.00	172,700.00
35420	Аж ахуйн материал	9,778,130.00	11,438,430.00
35440	Түлш, шатах тослох материал	221,370.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	785,502,126.91	756,261,957.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	785,502,126.91	756,261,957.19
392	Биет хөрөнгө	782,920,126.91	753,679,957.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	758,963,298.18	758,963,298.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39,609,158.82	-59,774,511.54
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,382,650.00	51,382,650.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,591,525.33	-45,481,646.37
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,829,063.00	27,829,063.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,798,349.24	-25,340,545.72
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	37,634,000.00	37,634,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,444,400.00	4,444,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,292,400.88	-3,934,900.36
39217	Ном	7,958,150.00	7,958,150.00
393	Биет бус хөрөнгө	2,582,000.00	2,582,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,582,000.00	2,582,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	795,982,326.91	767,873,087.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	270,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	270,000.00	00.00
413	Өглөг	270,000.00	00.00
4136	Бусад өглөг	270,000.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	270,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	795,712,326.91	767,873,087.19
51	Засгийн газрын хувь оролцоо	795,712,326.91	767,873,087.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	432,702,993.60	432,702,993.60
51101	Өмч: - төрийн	432,702,993.60	432,702,993.60
512	Хуримтлагдсан үр дүн	288,942,257.90	261,103,018.18
51210	Өмнөх үеийн үр дүн	288,942,257.90	288,942,257.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-27,839,239.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,067,075.41	74,067,075.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	795,982,326.91	767,873,087.19

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	97,884,188.00	95,801,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,649,588.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,649,588.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,649,588.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,649,588.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,234,600.00	95,801,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,234,600.00	95,801,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,234,600.00	95,801,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	123,474,465.97	123,640,239.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123,474,465.97	123,640,239.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121,629,765.10	121,134,522.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,777,676.90	55,176,660.35
210101	Үндсэн цалин	47,721,371.90	50,136,660.35
210105	Гэрээт ажлын хөлс	9,056,305.00	5,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,085,582.40	7,169,451.00
210201	Тэтгэврийн даатгал	4,818,142.80	4,962,383.92
210202	Тэтгэмжийн даатгал	566,837.11	551,766.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	453,631.86	441,413.18
210204	Ажилгүйдлийн даатгал	113,289.33	110,353.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1,133,681.30	1,103,533.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,855,869.83	27,731,521.25
210301	Гэрэл, цахилгаан	394,269.83	405,473.25
210302	Түлш, халаалт	24,461,600.00	27,306,048.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	20,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,093,800.00	1,600,720.00
210401	Бичиг хэрэг	372,000.00	213,900.00
210402	Тээвэр, шатахуун	284,000.00	558,820.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	245,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,077,800.00	583,000.00
2107	Томилолт, зочны зардал	226,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	226,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	216,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,500,835.97	29,240,169.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,500,835.97	29,240,169.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,844,700.87	2,505,717.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000.00	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000.00	250,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,814,700.87	2,255,717.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,814,700.87	2,255,717.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,590,277.97	-27,839,239.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-25,590,277.97	-27,839,239.72

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	94,272,106.00	95,801,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,272,106.00	95,801,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	94,234,600.00	95,801,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,234,600.00	95,801,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	37,506.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	37,506.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	94,002,106.00	96,071,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,002,106.00	96,071,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,119,899.13	93,295,282.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,777,676.90	55,176,660.35
210101	Үндсэн цалин	51,882,841.35	50,463,574.35
210105	Гэрээт ажлын хөлс	4,894,835.55	4,713,086.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,085,582.40	7,169,451.00
210201	Тэтгэврийн даатгал	4,782,439.80	4,962,383.92
210202	Тэтгэмжийн даатгал	602,540.15	551,766.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	453,631.91	441,413.18
210204	Ажилгүйдлийн даатгал	113,289.24	110,353.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1,133,681.30	1,103,533.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,875,869.83	27,731,521.25
210301	Гэрэл, цахилгаан	394,269.83	405,473.25
210302	Түлш, халаалт	24,461,600.00	27,306,048.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	20,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,344,770.00	937,350.00
210401	Бичиг хэрэг	245,000.00	175,900.00
210402	Тээвэр, шатахуун	505,370.00	337,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.00	245,000.00
210404	Ном, хэвлэл	59,500.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	174,900.00	179,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	830,000.00	1,664,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	230,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	83,300.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,581,000.00
2107	Томилолт, зочны зардал	226,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	226,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	480,000.00	516,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	390,000.00	300,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,882,206.87	2,775,717.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,506.00	520,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	37,506.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000.00	520,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,814,700.87	2,255,717.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,814,700.87	2,255,717.40
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	270,000.00	-270,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	270,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	270,000.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	430,120,993.60	712,577.80	-70,494,599.87	360,338,971.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	430,120,993.60	712,577.80	-70,494,599.87	360,338,971.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	24,726,648.01	24,726,648.01
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,702,993.60	74,067,075.41	288,942,257.90	795,712,326.91
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	432,702,993.60	74,067,075.41	288,942,257.90	795,712,326.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	432,702,993.60	74,067,075.41	288,942,257.90	795,712,326.91
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-27,839,239.72	-27,839,239.72
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,702,993.60	74,067,075.41	261,103,018.18	767,873,087.19

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,801,000.00	93,815,282.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,801,000.00	93,815,282.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,551,000.00	93,295,282.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,422,200.00	55,176,660.35
210101	Үндсэн цалин	51,382,200.00	50,463,574.35
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,713,086.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,617,000.00	7,169,451.00
210201	Тэтгэврийн даатгал	5,360,100.00	4,962,383.92
210202	Тэтгэмжийн даатгал	564,200.00	551,766.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	451,400.00	441,413.18
210204	Ажилгүйдлийн даатгал	112,900.00	110,353.59
210205	Эрүүл мэндийн даатгал	1,128,400.00	1,103,533.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,052,400.00	27,731,521.25
210301	Гэрэл, цахилгаан	726,400.00	405,473.25
210302	Түлш, халаалт	27,306,000.00	27,306,048.00
210303	Цэвэр, бохир ус	20,000.00	20,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	937,900.00	937,350.00
210401	Бичиг хэрэг	204,100.00	175,900.00
210402	Тээвэр, шатахуун	337,800.00	337,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,200.00	245,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	145,800.00	179,000.00
2105	Нормативт зардал	100,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,748,000.00	1,664,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	83,700.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,300.00	83,300.00
210604	Урсгал засвар	1,581,000.00	1,581,000.00
2107	Томилолт, зочны зардал	133,500.00	00.00
210702	Дотоод албан томилолт	133,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	540,000.00	516,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250000.00	520000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	520,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	520,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	95,801,000.00	93,815,282.60
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	95,801,000.00	93,815,282.60

132001	Орон нутгийн төсвөөс	95,801,000.00	93,815,282.60
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	270,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	06.00	06.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00
620004	Гэрээт ажилтан	01.00	01.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	06.00	06.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	04.00	04.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	01.00	01.00
650010	Гэрээт ажилтан	01.00	01.00

3 . Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлгий сумын Соёлын төв нь соёл, урлагийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 989.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 123,640.2 төгрөгийн 1 хувь буюу 1,236.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 989.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Соёлын төв 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,109.2 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	270.0	0	-270.0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	10,210.2	11,611.1	1,400.9
Үндсэн хөрөнгө	785,502.1	756,262.0	-29,240.1
Нийт хөрөнгө	795,982.3	767,873.1	-28,109.2
Өр төлбөр	270.0	0	-270.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	795,712.3	767,873.1	-27,839.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	795,982.3	767,873.1	-28,109.2

Бараа материалын дансны үлдэгдэл 11,611.1 мянган төгрөг болж 1,400.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 756,262.0 мянган төгрөг болж 29,240.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 767,873.1 мянган төгрөг болж 27,839.2 мянган төгрөгөөр буурсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,083.2 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 165.7 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 95,801.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 95,801.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөр 95,801.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 95,801.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 98,801.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 93,815.3 мянган төгрөгийг зарцуулж 1,985.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 93,815.3 мянган төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь төсвийг 1,985.7 мянган төгрөгөөр хэмнэж, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 270.0 мянган төгрөг байснаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Өлгий сумын Соёлын төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож 12 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ~~холбогдох~~ ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 25-ны өдөр